



ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2020 оны 43 болон 44 дэх долоо хоног

ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2020 оны 10-р сарын 19-өөс 10-р сарын 30-ны байдлаар

Ковид-19 дэлхий нийтээр хурдтай тархаж, цар тахлын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтворжуулахад улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилгоор Монголбанкнаас долоо хоног тутам бэлтгэн хүргэж буй гадаад орчны тойм мэдээллийн 26 дахь дугаарыг хүргэж байна.

1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

- **Олон Улсын Валютын Сангаас** 10-р сарын 21-ны өдөр нийтэлсэн “Бүс Нутгийн Эдийн Засгийн Төлөв” тайланд **Евро бүсийн эдийн засаг 2020 онд 7 хувиар агшиж, 2021 онд 4.7 хувиар өсөхөөр төсөөлжээ.** Европын улс орнууд хөл хориогоо цуцалснаар эдийн засаг сэргэж эхэлсэн ч цар тахлын тархалт нэмэгдэж, 2 дахь давалгаа гарах эрсдэл өндөр байна. Мөн эдийн засгийн сэргэлт цар тахлын нөхцөл байдал, хүмүүсийн хандлага болон цаашдын бодлогын шийдвэрүүдээс ихээхэн хамаарахаар байна. Евро бүсийн бодит ДНБ 2-р улиралд өмнөх оны мөн үеэс 40 хувиар агшсан ч цар тахлаас үүдэлтэй хохирол үүнээс ч их байж болох байсныг эрх баригчид урьд өмнө нь хэрэглээгүй дорвитой арга хэмжээнүүдийг шуурхай авсны үр дүнд бууруулж чадсан гэж үзэж байна. Европын улс орнуудын ЗГ-ууд их хэмжээний төсвийн багц арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлснээр айл өрх, ААН-үүд болон 54 сая орчим ажлын байрыг хадгалж чаджээ. Төв Банкууд зах зээлийн хөрвөх чадварыг сайжруулах, зээлийн зардлыг бууруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор уламжлалт болон уламжлалт бус мөнгөний тэлэх бодлого хэрэгжүүлсэн. Хямралд өртсөн банк болон харилцагчдын хүндрэлийг бууруулах зорилгоор макро зохистой бодлогын арга хэмжээнүүдийг мөн амжилттай авч хэрэгжүүлсэн гэж үзэж байна.
- **Евромонитор байгууллагаас дэлхийн эдийн засаг 2020 онд 5 хувиар агших төсөөллийг 10-р сарын 23-нд нийтэллээ.** Ирэх оны хувьд дэлхийн эдийн засгийг 3.5-6.5 хувийн интервалд, дунджаар 5 хувиар өсөхөөр төсөөлсөн бөгөөд улмаар дэлхийн бодит эдийн засгийн төсөөлөл 2021 онд хямралын өмнөх үеийн төсөөллөөс 6 хувиар бага түвшинд очих юм. Суурь төсөөлөлд цар тахлын дэгдэлтийн оргил үе 2020 оны эхний 3 улиралд үргэлжилж, 4-р улиралд хоёр дахь давалгаа бий болох ч улс орнууд тархалтыг хяналтандаа оруулна, 2021 оны дунд үеэс вакцин бүх нийтэд хүртээмжтэй болно гэж таамагласан байна. АНУ, Канадын эдийн засаг хүлээлтээс хурдан сэргэж төсөөллийг өмнөх улирлын төсөөллөөс дээшлүүлсэн бол хөгжиж буй орнуудын эдийн засгийн төлөвийг бууруулжээ.
- **Евро бүсийн үйлчилгээний PMI индекс 9-р сард 48.0 байсан бол 10-р сард 46.2 болж буурсан нь эдийн засгийн идэвх буурсан болохыг харуулж байна.** Энэ нь сүүлийн 5 сарын хамгийн доод түвшин боллоо.



Үйлчилгээний дэд индексүүд сүүлийн 8 жилийн хамгийн доод түвшинд хүрч буураад байгаа ч үйлдвэрлэлийн PMI индекс 9-р сард 53.7 байсан бол 10-р сард 54.4 болж өссөн нь сүүлийн 26 сарын дээд түвшин байлаа.

- **АНУ-ын эдийн засаг** 2-р улиралд 31.4 хувиар агшсан бол **3-р улиралд урьдчилсан тооцоогоор өмнөх улирлаас жилийн 33.1 хувиар сэргэжээ.** Хөл хорио, хязгаарлалтуудыг сулруулсаны зэрэгцээ төсөв, мөнгөний их хэмжээний тэлэх бодлогууд нь хэрэглээ, хөрөнгө оруулалтыг тэтгэж эдийн засгийн сэргэлтийг дэмжив. Эрүүл мэнд, нийтийн хоолны үйлчилгээ, зочид буудлын үйлчилгээ болон автомашин, гэр ахуйн тавилга, гутал, хувцасны хэрэглээ нэмэгдэж нийт хувийн хэрэглээ өмнөх улирлаас жилийн 82 хувиар өсчээ. Цар тахалтай холбоотой тээврийн хэрэгсэл, ялангуяа нисдэг тэргийн дотоод болон гадаад эрэлт огцом нэмэгдэж, хувийн хөрөнгө оруулалтыг тэтгэв. Цар тахлын улмаас гадаад худалдааны алдагдал сүүлийн 8 жилд хамгийн өндөр буюу ДНБ-ий 3.5 хувьд хүрч тэллээ. Гэвч төсвийн өрхөд үзүүлж буй тэлэх бодлогын нөлөө ирэх улирлаас сулрах, цар тахлын дэгдэлт зарим мужуудад нэмэгдэж, өндөр давтамжтай үзүүлэлтүүд муудаж байгаа тул 4-р улиралд өсөлт саарах хүлээлттэй байна.
- **Оросын Төв банк** 9,10-р сарын 2 удаагийн хурлаар **бодлогын хүүг 4.25 хувьд хадгалахаар шийдэв.** Оросын Төв банкны тэргүүн Эльвира Набиуллинагийн мэдэгдсэнээр бодлогын хүүг дахин бууруулах орон зай бага байгаа бөгөөд хэзээ, хэр хэмжээгээр өөрчлөх нь ирэх саруудад эдийн засгийн нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдөхөөс хамаарах аж. Төв банк инфляцийн эрсдэл, санхүүгийн тогтвортой байдал, улс төрийн байдал, цар тахлын байдал болон бусад асуудлуудыг харгалзан үзэж, бодлогын

хүүгээ энэ ондоо багтаж өөрчлөхгүй байх хүлээлттэй байна. Тус улсын эдийн засаг энэ онд 4-5 орчим хувиар агшихаар байгаа нь Дэлхийн банкнаас төсөөллөөс 1 нэгж хувиар өөдрөг тооцоолол юм. Харин 2021 онд эдийн засаг 3-4 хувиар өсөх хүлээлттэй байгаа нь голчлон дотоодын хэрэглээ өснө гэж үзэж байгаатай холбоотой. Гэвч 2021 оны өсөлтөд одоогийн үүсээд байгаа геополитикийн асуудал болон түүнээс үүдэлтэй газрын тосны үнийн асуудал эрсдэл үүсгэж байгааг Набиуллина онцолжээ.

- **БНСУ-ын хэрэглэгчийн итгэл 2009 оны дэлхийн санхүүгийн хямралаас хойших хамгийн өндөр дүнгээр өсөв.** Хэрэглэгчийн мэдрэмжийн индекс 10-р сард 12.2 нэгжээр өсч 91.6-д хүрсэн нь 2020 оны 2-р сараас хойшхи хамгийн өндөр түвшин боллоо. Энэ нь сарын дүнгээр 2009 оны 4-р сараас хойшхи хамгийн өндөр өсөлт юм. КОВИД-19-ийн тархалт буурч, ЗГ-аас хөл хорионы дэглэмийг сулруулснаар өрхийн эдийн засаг, санхүүгийн нөхцөл байдал сайжирч байгааг тус улсын Төв банк онцолсон байна. Цаашид сэргэлтийг эрчимжүүлэх зорилгоор БНСУ-ын ЗГ хэрэглээг дэмжих аян зарлаж, 11-р сард үндэсний хэмжээнд худалдааны арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөж байна.
- **Европын санхүүгийн захирлуудын бизнесийн төлөвийн талаарх хүлээлт хавар авсан судалгааны үр дүнгээс харьцангуй дээшилсэн байна.** “Deloitte” компаниас Европын нийт 18 улсын томоохон компаниудын 1550 гаруй санхүү хариуцсан захирлуудын (CFO) дунд явуулсан судалгааны эхний үр дүнг тайлагнажээ. Тэдний талаас илүү хувь нь 3 сарын өмнө компанийнхаа санхүүгийн хэтийн төлөвийг тодорхой бус гэж үзэж байсан бол одоо хэтийн төлөвийн талаар өөдрөг төсөөлөлтэй байгаа бөгөөд 3-р сарын үетэй харьцуулахад 5 дахин нэмэгдсэн



байна. Харин Итали болон Испанийн санхүү хариуцсан захирлууд бусад орнуудаас арай гутранги бодолтой байна. Компаниудын орлогын хүлээлт Европ дахь нөхцөл байдал сайжирсныг илтгэж байгаа бөгөөд санхүүгийн захирлуудын 54 хувь нь орлогоо ирэх 12 сарын хугацаанд өснө гэж найдаж байна гэжээ. Гэвч ихэнх бизнесүүд цар тахлын өмнөх орлогын түвшинд хараахан хүрээгүй байна. Бизнес эрхлэгчдийн 23 хувь нь КОВИД-19-ийн өмнөх түвшинд эсвэл түүнээс дээш түвшинд үйл ажиллагаа явуулж байгаа, 13 хувь нь жилийн эцэс гэхэд хямралын өмнөх түвшинд эргэж очно гэж төлөвлөж байгаа бол 44 хувь нь хамгийн эртдээ 1 жилийн дараа хямралын өмнөх түвшинд хүрэх хүлээлттэй байна. Гэсэн хэдий ч улс орнуудын хоорондын ялгаа маш том байна. Жишээлбэл, Германы санхүү хариуцсан захирлуудын 53 хувь нь орлогын түвшин энэ оны сүүл гэхэд хямралаас өмнөх түвшинд очно гэсэн хүлээлттэй байгаа бол Их Британийн санхүү хариуцсан захирлуудын зөвхөн 21 хувь нь л ижил хүлээлттэй байна. Салбар хоорондын ялгаа бүр ч том байна. Аялал жуулчлалын салбарын ердөө 4 хувь нь л 2020 оны эцэст орлогын хэвийн түвшиндээ хүрэх

хүлээлттэй байгаа бол жижиглэнгийн худалдааны салбарын 43 хувь нь ижил хүлээлттэй байна. Ирэх 12 сарын хугацаанд ажиллах хүчний тоо их хэмжээгээр буурна гэж тооцоолж байсан компаниудын тоо 3-р сартай харьцуулахад бага зэрэг буурчээ. Санхүү хариуцсан захирлуудын 38 хувь нь ирэх 12 сарын хугацаанд хөрөнгийн зардлаа танах, 26 хувь нь эсрэгээрээ зардлаа нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй байна. Тэдний 60 орчим хувь нь бизнесийн өргөтгөл, үйл явцаа сайжруулахад (автоматжуулалт гэх мэт), 47 хувь нь програм хангамж, мэдээлэл технологио сайжруулахад хөрөнгө оруулалт хийх төлөвлөгөөтэй байна. КОВИД-19 цар тахал эдийн засгийн өсөлтийг бууруулсан ч дижитал эдийн засгийн өсөлтийг хурдасгасан нь дамжиггүй юм.

Эх сурвалж:


1. IMF, [Regional Economic Outlook October-2020](#)
2. BEA, [US GDP 2020Q3 advance estimate](#)
3. Bloomberg, [Korea Consumer Confidence Jumps](#)
4. CNBC, [Russia remains cautious on interest rates](#)
5. Euromonitor insitute, [Global Economic Outlook: Oct 2020](#)
6. Deloitte, [Global Economic Outlook](#)



2

БНХАУ-ЫН ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- **Хятадын эдийн засгийн сарын үзүүлэлтүүд эдийн засгийн төлөв байдлын талаар холимог сигнал өгч байна.** Стандарт чартеред байгууллагаас Хятадын 500 гаруй жижиг дунд үйлдвэрлэгчдийн дунд сар бүр хийдэг түүвэр судалгаагаар ЖДҮ-ийн бизнесийн хандлага илүү болгоомжлох төлөвт шилжсэн байна. Тухайлбал, хүлээлтийн дэд индексийг харвал 3-р улиралд 54.7 байсан бол 10-р сард 52.6 болж буурчээ. Хятадын орон сууцны борлуулалтын өсөлт энэ онд цар тахлаас үл хамааран харьцангуй эрүүл байсан боловч барилгын салбарт олгох санхүүжилтийг хязгаарлах бодлогын нөлөөгөөр өсөлт нь саарч эхэллээ. Харин Хятадын автомашины борлуулалт үргэлжлэн сайжирч, эерэг өсөлттэй байгаа нь хэрэглээг тэтгэж байна. Ерөнхийдөө 10-р сарын үзүүлэлтүүд харьцангуй тогтвортой, Блүмбергээс 8 индикаторыг нэгтгэн тооцдог эдийн засгийн төлөвийн нэгдсэн индикатор 10-р сарын байдлаар өмнөх сарын түвшинд хадгалагдаж байна.




Source: CEIC and BBVA Research.

Зураг 1. Хятадын боловсруулах салбарын хөрөнгө оруулалт агшилттай байгаа ч үл хөдлөх хөрөнгө, дэд бүтцийн салбаруудын хөрөнгө оруулалт өсөлттэй байна.

- **BBVA судалгааны агентлагаас** Хятадын эдийн засгийн өсөлтийн төлөвийг 10-р сарын 22-ны өдөр шинэчлэн зарлалаа. Тус байгууллагын төсөөллөөр Хятадын эдийн засаг энэ оны сүүлийн улиралд 6.0 хувиар өсч,

2020 онд жилийн 2.2 хувиар өсөх (ОУВС 1.9 хувь), 2021 онд эдийн засаг 7.5 хувиар өсөхөөр (Блүмберг 8 хувь, ОУВС 8.2 хувь) төсөөлж байна. Жижиглэн худалдаа, хөрөнгө оруулалт сэргэж, дотоод эрэлт нэмэгдсэн, цар тахалтай холбоотой тоног төхөөрөмж, эрүүл мэндийн бүтээгдэхүүний экспортын нөлөөгөөр экспортын өсөлт эерэг байгаа зэрэг нь өсөлтийг дэмжиж байна. Цашид төсөв, мөнгөний нормалчлах бодлого хэрэгжих хүлээлттэй, АНУ, Хятадын хоорондын худалдааны зөрчилдөөн сүүлийн саруудад хурцадсан, гадаад эрэлт сул хэвээр байгаа тул экспортын өсөлт тогтвортой хадгалагдах нь эргэлзээтэй зэрэг нь өсөлтийн гол эрсдэлүүд болж байна.

- **Төсөв, мөнгөний бодлого:** Хятадын эдийн засаг V хэлбэрээр сэргэж байгаа тул энэ оны сүүлийн хагаст эрх баригчид төсөв, мөнгөний бодлогыг нормалчлах бодлого баримталж байна. Хятадын Ардын банк 2020 оны сүүлийн сарууд болон 2021 онд хүүг бууруулахгүй байх, банкуудын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг мөн энэ ондоо бууруулахгүй байх хүлээлттэй байна. Төсвийн бодлогын хувьд өмнө нь зарласан 2 арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх боловч нэмэлт төсвийн дэмжлэгийг хэрэгжүүлэхээргүй байна.



Зураг 2. Хятадын төсвийн хөрөнгө оруулалт нийт хөрөнгө оруулалтыг тэтгэж байна



Хятадын Коммунист намын Төв Хороо 2020 оны 10-р сарын 26-29-ны өдрүүдэд хуралдаж, **14 дэх удаагийн 5 жилийн төлөвлөгөө буюу 2021-2025 оны төлөвлөгөөг хэлэлцлээ.** Ирэх 5 жилийн төлөвлөгөөнд эдийн засгийн өсөлтийн зорилтыг 5 хувь болгож бууруулах эсвэл нэрлэсэн тоон зорилтгүй болгож, өсөлтийн чанарыг чухалчлах, эдийн засгийн бүтцийн өөрчлөлтүүдийг үргэлжлүүлэх, санхүүгийн зах зээлийг либералчлах, чөлөөт худалдааны бүс байгуулах, ГШХО татах зэргээр эдийн засгийг илүү нээлттэй болгох, шинэ технологийн (big data, 5G, AI, block chain, cloud computing зэрэг чиглэлээр) хөгжлийг дэмжих, санхүүгийн тогтвортой байдлыг хангаж, санхүүгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, байгаль орчноо хамгаалж, ногоон эдийн засгийг дэмжих чиглэлээр бодлогууд хэрэгжүүлэх зэрэг нь багтжээ. Ирэх 5 жилийн төлөвлөгөөнд онцолж буй “Dual circulation” өсөлтийн загвар нь 1. өсөлтийг бий болгогч гол тулгуур нь дотоод эдийн засаг өөрөө байх (хэрэглээний болон нийлүүлэлтийн гинжин сүлжээний дотоод эдийн засгийн эргэх холбоог нэмэгдүүлэх, 5 метрополитан бүсийг барьж байгуулах), 2. Дотоод болон гадаад эдийн засгийн харилцан уялдааг сайжруулах замаар тогтвортой эдийн засгийн өсөлтийг дэмжих (нэг бүс, нэг зам бодлогын хүрээнд гадаад худалдааг өргөжүүлэх, санхүүгийн зах зээлийг либералчлах, эдийн засгийг нээх бодлогууд багтана) юм.

- **Хятадын коксжих нүүрсний эрэлт ойрын хугацаанд өндөр байхаар**

байна. Хятадын коксжих үйлдвэрүүд өвлийн улирлын үйлдвэрлэлийн нөөц бэлтгэлээ базааж байгаа тул 10, 11-р саруудад коксжих нүүрсний эрэлт өмнөх саруудаас хүчтэй нэмэгдэхээр байна. Хятадын төрийн өмчит нүүрсний компаниудыг 10-р сарын 1-с Австралийн нүүрсний худалдан авалтаа зогсоох албан бус чиглэл өгсний дараагаас Хятадын баруун, хойд мужуудын үйлдвэрүүд Монголоос импортлох коксжих нүүрсний эрэлтээ нэмэгдүүлээд байна. Монгол Улс энэ оны 9-р сард Хятад улс руу 4.65 сая тонн нүүрс экспортлосон (оны эхний 9 сард 19.82 сая тоннд хүрсэн) нь өмнөх сараас 17.2 хувиар өссөн дүн юм. Гашуун сухайт боомтоор нэвтэрч буй ачааны машины тоо 9-р сард өдрийн 1000 байсан бол 10-р сарын дунд үед өдрийн 1200 болж нэмэгдлээ. Гэхдээ коксжих нүүрсний импортын энэ оны квот дуусах дөхөж байгаа болон Австралийн нүүрсэнд тавьсан хориг ойрын хугацаанд сулрахааргүй байгаа тул Хятадын нийт коксжих нүүрсний импорт энэ оны 4-р улиралд өмнөх оны мөн үеэс 3-4 сая тонноор бага байх төлөвтэй байна.


Эх сурвалж:

1. China Insight:China's Recovery is Showing Mixed Signals, Bloomberg
2. China Economic Outlook 2020Q4, BBVA research
3. China Coal/Coke Market Monthly, Oct 2020, Sxcoal.com
4. <https://www.awareporters.com/2020/10/27/the-cpcs-fifth-plenum-and-chinas-14th-five-year-plan-2021-2025/>


МОНГОЛ УЛСЫН ЭКСПОРТЫН ГОЛ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТ

Бодит гүйцэтгэл							Товч тайлбар
	Үнэ (-1 day) 2020/10/27	Өөрчлөлт					
		daily	weekly	monthly	year to date	YoY	
Зэс	6779	0.0%	-1.0%	3.0%	10.0%	15.0%	Дэлхийн хэмжээнд КОВИД-19-ийн халдварын тохиолдол нэмэгдэж, АНУ-ын ЗГ Ерөнхийлөгчийн сонгуулиас өмнө эдийн засгийг дэмжих шинэ багц арга хэмжээг авах үгүй нь тодорхой бус байгаагаас зэсийн үнэ бага зэрэг буураад байна.
Төмрийн хүдэр	114.7	-1%	-2.0%	-3.0%	24.0%	34.0%	БНХАУ энэ онд барилгын салбараа эрчимтэй дэмжсэний үр дүнд төмрийн хүдрийн эрэлт сайн байгаа хэдий ч төмрийн хүдэр нийлүүлэгч гол улсууд гарцаа улам нэмсээр байгаа нь үнэ буурахад нөлөөлж байна.
Алт	1908	0.0%	0.0%	1.0%	25.0%	28.0%	Дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдал өндөр, хөгжингүй орнуудад мөнгөний тэлэх бодлогууд үргэлжилж байгаа тул аюулгүй хөрөнгө оруулалтад тооцогддог алтны эрэлт өндөр байна.
Газрын тос (Брент)	41.2	2%	-5.0%	-3.0%	-38.0%	-33.0%	КОВИД-19-ийн халдварын тохиолдол нэмэгдэж байгаатай зэрэгцээд газрын тосны үнэ доош уналаа. 10-р сарын сүүлийн байдлаар АНУ-д газрын тосны агуулахын нөөц долоодугаар сараас хойших хамгийн дээд түвшиндээ хүрлээ.

Зураг 3. Дэлхийн зах зээл дээрх алт, төмрийн хүдрийн спот үнэ



Зураг 4. Дэлхийн зах зээл дээрх зэс, газрын тосны үнэ



Эх сурвалж: Блумберг